

Математик: 2-р анги 2012-11-13

Хугацаа: 4 цаг

Нэгж хичээлийн сэдэв: Жимсний тоог тоолцгооё

Зорилго: Үржүүлэх үйлдлийг таниулах

Зорилт: -Үйлдлийн гишүүдийн нэр

-Ижил нэмэгдэхүүний нийлбэрийг олох

-Ижил нэмэгдэхүүний нийлбэрийг үржвэр хэлбэрээр тэмдэглэх

- Үржвэрийг ижил нэмэгдэхүүнээр илэрхийлэх

Хэрэгцээ: Амьдралын ойр зуурын хялбар тооцооллыг хийх чадварт суралцах

Хамрах хүрээ: Ижил тоогоор багцалж зурсан зүйлс болон , ижил нэмэгдэхүүнүүдийн нийлбэрийг олох чадвартай 2-р ангийн сурагчид

Агуулга:

Мэдлэг	Чадвар
- Багц юмсын тоо - Нэмэх үйлдэл, түүний гишүүд - Үржүүлэх үйлдэл - Үржүүлэх үйлдлийн тэмдэглэгээ - Үржүүлэх үйлдлийн гишүүд	- Бодит юмсыг багцлах - Нэмэх үйлдэл, түүний гишүүдийг нэрлэх - Ижил нэмэгдэхүүний нийлбэрийг олох - Ижил нэмэгдэхүүний нийлбэрийг үржвэр хэлбэрээр тэмдэглэх

Нэгж хичээлийн цагийн төлөвлөлт:

№	Ээлжит хичээлийн сэдэв	цаг	Хичээлд тусгах зүйлүүд
1	Ижил тоогоор багцалж зурах, хүрээлэх , бичих	1	Хайрцагтай шооноос хүүхэд бүр 30 ш-ийг тоолж авах, тоолсон аргаараа тасалж тавих, яагаад энэ хэлбэрээр сонгосноо тайлбарлах, зурах боломж олгох гэх мэтээр 42, 24 ш сувд, шагай гэх мэт
2	Ижил нэмэгдэхүүний нийлбэр олох	1	Өмнөх цагийн хичээл дээр багцалж зурсан зүйлээ тоогоор илэрхийлж ижил нэмэгдэхүүний нийлбэрийг ялгуулж нэмүүлэх
3	Ижил нэмэгдэхүүнийг хялбар аргаар бичих	1	Ижил нэмэгдэхүүний нийлбэрийг хялбар аргаар бодох үржүүлэх үйлдлийн утга санааг ойлгуулж тэмдэглэх аргыг таниулна
4	Бататгал	1	Өмнөх үзсэн мэдлэгүүдийг бататгах бүтээлч даалгавруудыг оруулах $2+2+2+2=\dots*\dots$ $4+4=\dots*\dots$ $9*4=$ $4*9=$

Хэрэглэгдэхүүн: шүр, шоо, хэрчмэл цифрууд, бусад олон тоогоор ашиглаж болох материал

Хичээл № 3 –ын загвар. Зөвхөн төлөвлөлт

Ээлжит хичээлийн сэдэв: Жимсний тоог олцгооё

Зорилт: Ижил нэмэгдэхүүнүүдийг үржвэр хэлбэрээр

Үржүүлэх үйлдлийг ижил нэмэгдэхүүний нийлбэр хэлбэрээр бичих

Хэрэглэгдэхүүн: шинэ жилийн ая, самбар, тодорхойлолт, үйлдлийн гишүүдийн нэр хэрчмэл үгээр, Сантагийн захидал \хүүхдийн тоогоор\

Үе шат	Суралцагчийн үйл ажиллагаа	Багшийн дэмжлэг	Анхаарах зүйл
	1.Нэмэх үйлдэл 2.Нэмэгдэхүүн+ нэмэгдэхүүн= Нийлбэр	$7+7=$ $2+2+2+2=$ $4+6+3=$ $10+10+10=$ нэрлээрэй.	Хичээлд хэрхэн оролцохыг анхааруулан хэлэх 1.самбарт тоог бичээд асуултаа тавина.

Сэдэлжүүлэлт 5 мин	3.Хасах үйлдэл 4.Сурагчдын төсөөлсөн таамаглалыг бичнэ 5. Ялгаатайг нь олох 6. Ижил нэмэгдэхүүнүүд байна	3.Өөр ямар үйлдэл мэдэх вэ? 4.Нэмэх, хасах үйлдлээс өөр үйлдэл байдаг болов уу? 5.Нэмэгдхүүнийг ажиглаад ялгаатайг нь олоорой (ялгаатай үйлдлийн доогуур өөр өнгийн шохойгоор зурна) 6.Бусад нь юугаараа ижил вэ? Ижил нэмэгдэхүүнүүд	4.Сурагчдын дэвшүүлсэн таамаглалыг самбарт бичнэ 5.4+6+3 үйлдлийг цаасаар халхлах үйлдлийг дэвтэрт нь бичүүлэн бодуулах 6.“Ижил нэмэгдэхүүн” нь бидний өнөөдрийн үзэх хичээлд чухал зүйл болохыг ойлгуулан хэлээд тодорхойлолт бичих хэсгийн эхэнд байрлуулна ижил нэмэгдэхүүн 7.Jingle Bells- ийн ая сонсоно, боломжтой бол санта клаусийн бичлэгийг харуулах 10.Цаасаа салгахгүй байхыг анхааруулж тайлбарлана.
Утга санааг ойлгох шат 20 мин	8.Санта клаусын бэлгийг задална. 9.Ямар ямар жимс хэд хэдэн ширхэг байгааг тодорхойлно. Хүүхэд тус бүрт: 1. Алим 2 ширхэг 2. .Хан боргоцой1ширхэгЖүрж 4ширхэг байгааг хэлнэ. 10.Баг бүр тохирох нүдтэй цаасаа сонгоно. 11. Хайчилсан 3 цааснаас 1-ийг нь авна 12. Бичихдээ хэрхэн бичихийг анхааралтай сонсоод боломжтой бол хүүхэд бүр өөрт оногдсон алимны тоог өөрөө 1, 1 нүдэнд бичих / нар зөв эргэн цэгцтэй ээлж дарааллаар бичих 13.Нэмэх үйлдлийн тусламжтайгаар бэлгэнд бүгд хэдэн алим авсан болохыг олж хариуг бүр багийнхаа алимны тоог ТӨМ цаасан дээр фломастераар бичиж харьцуулна. Олсон аргаа тайлбарлана. 14. багийн гишүүдээс цэвэр гоё бичсэн нь самбарт “алим”ын дор байрлуулна. 15. Самбарт байрлуулсан бичилтэд ажиглалт хийн эхлээд адил талыг дараа нь ялгаатай шинжүүдийг олж тус бүр дээр хэдэн ширхэг ямар нэмэгдэхүүн байгааг тодорхойлж хэлнэ.	7.Та нар хичээлдээ идэвхтэй сайн оролцсон болохоор манай ангид нэгэн зочин ирж байна. Таагаарай 8.Санта клаус та нарт бэлэг илгээсэн байна. Ямар бэлэг явуулсан бол сонирхоцгооё 9.Сурагчдын бэлэгэнд I. юу байгааг II. тус бүр хэд хэд байгааг III. хүүхэд бүрийн бэлэг ижил эсэхийг ярилцуулан олуулна. 10.Өмнөө байгаа цааснаас өөрийн багийн хүүхдийн тоотой тэнцүү дөрвөлжин нүдтэй цаасыг сонгоорой 11. Хайчилсан 3 цааснаас 1-ийг нь аваарай 12. бичихдээ хэрхэн бичихийг анхааруулна. • Дөрвөлжин дэвтрийн нүд гэж бодоод томоор бичээрэй • Хүүхэд бүрт байгаа алимныхаа тоог 13.Танай багт нийт хэдэн ширхэг алим байгааг та нарын мэдэх ямар үйлдлийн тусламжтайгаар олж болох вэ?, Олоорой гэж даалгаврыг танилцуулна. Нэмэх үйлдлийн тусламжтайгаар бэлгэнд бүгд хэдэн алим авсан болохыг олж хариуг нэг нь цаасан дээр бусад нь дэвтэртээ бичихийг ойлгуулна. 14. Үйлдэл гүйцэтгэсэн цаасаа самбараас “алим” үгийг олж түүний доор байрлуулахыг хэлнэ. 15.Мөн адил алхмаар самбарт байрлуулахыг зөвлөнө. 16. Алимны тоог олсон баг бүрийн үйлдлийг ажиглан • эхлээд адил талыг дараа нь • Ялгаатай шинжүүдийг олуулж тус бүр дээр хэдэн ширхэг ямар нэмэгдэхүүн байгааг олуулгах.	Сонголтоос үлдсэн цаасыг багш заавал хурааж авна 12. бичихдээ хэрхэн бичихийг анхааруулна. Бүдрэх шалтгаан: алимны зурагтай хүснэгтэд 2.4.1. өөрт байгаа жимсний тоог бичиж магад 13. Нэг нь цаасан дээр бичиж байхад бусад нь дэвтэртээ бичихийг анхааруулах 14, 15, 16.Нэг дор 1 шугаманд байрлуулахад багш туслана “нэмэгдэхүүнүүдийн” гэдэг үгийг багш уншиж өгөх Үржвэр хэлбэрт оруулж бичихдээ дүрсийг арилгана

Утга санааг ойлгох шаг20 мин	18. АЛИМ 2+2+2+2+2=10 5ширхэг 5□ 2 2+2+2+2+2+2+2=14 7 ширхэг 7□ 2 2+2+2+2+2+2=12 6 ширхэг 6□ 2 2+2+2+2= 8 4 ширхэг 4□ 2 19.(+) (-) тэмдгээс өөр үйлдлийн тэмдэг байдаг гэж сонсож байсан , эсвэл мэдэх сурагачдын таамаглалыг бичнэ. • 1 • 2 Энэ үг нь 17 үсгээс бүтсэн тул уншихад бэрхшээл үүсдэг үйлдлийн гишүүдийг нэрийг таамаглуулна. 22.үйлдлийн гишүүдийг нэрийг таамаглуулна. үржигдэхүүн + үржигдэхүүн = үржвэр 23. Хүүхдүүд багшийн хэлснийг хуруугаараа илэрхийлнэ	18. АЛИМ 2+2+2+2+2=10 5ширхэг 5□ 2 2+2+2+2+2+2+2=14 7 ширхэг 7□ 2 2+2+2+2+2+2=12 6 ширхэг 6□ 2 2+2+2+2= 8 4 ширхэг 4□ 2 19.Таамаглалд тулгуурлан үржүүлэх үйлдлийг таниулан тодорхойлолтыг гаргуулж нийтээр уншуулна. тодорхойлолтыг нийтээр уншуулна Хүүхдүүдийн таамаглалд т тулгуурлан үржүүлэх үйлдлийг таниулна. 20.6 ш 2 6х2=12 7ш 2 7х2=14 4ш 2 4х2=8 5ш 2 5х2=10 21. Ижил нэмэгдэхүүнүүдийн нийлбэр олох үйлдлийг үржүүлэх үйлдэл гэнэ. 22. үржигдэхүүн + үржигдэхүүн = үржвэр 23. Багш гараараа гурван 5, хоёр 4,таван ... Гэх мэт	Энэ үг нь 17 үсгээс бүтсэн тул уншихад бэрхшээл үүсэх тул тодорхойлолтыг нийтээр уншуулна Ижил нэмэгдэхүүнүүдийн нийлбэр олох үйлдлийг гүйцэтгэсэн болохыг нь тодорхойлуулан гаргуулна. 22.дэвтэрт нь бичүүлэх үржүүлэх үйлдэл болон тэмдэглэгээтэй танилцуулна. Олон улсын нэгдсэн тэмдэглэгээ нь “Х” болохыг анхааруулан хэлж өгөх 1-р нэмэгдэхүүн, 2-р нэмэгдэхүүн, нийлбэр гэж байгаа бол үржүүлэх үйлдлийн гишүүн тус бүрийг юу гэж нэрлэж болох вэ? Алжаал тайлах дасгал Багш гараараа гурван 5, хоёр 4,таван 1.м
	Батагтал 5 мин 24. Хан боргоцой 1+1+1+1+1+1+1=7 7 ширхэг 7□ 1 1+1+1+1+1=5 5 ширхэг 5□ 1 1+1+1+1=4 4 ширхэг 4□ 1 1+1+1+1+1+1=6 6 ширхэг 6□ 1 25. Жүрж 4+4+4+4+4+4=24 6 ширхэг 6□ 4 4+4+4+4+4=20 5 ширхэг 5□ 4 4+4+4+4+4+4+4=28 7 ширхэг 7□ 4 4+4+4+4=16 4 ширхэг 4□ 4 25. сурах бичгээс 2 бодлого ажиллана	24. Хан боргоцой 1+1+1+1+1+1+1=7 7 ширхэг 7□ 1 1+1+1+1+1=5 5 ширхэг 5□ 1 1+1+1+1=4 4 ширхэг 4□ 1 1+1+1+1+1+1=6 6 ширхэг 6□ 1 25. Жүрж 4+4+4+4+4+4=24 6 ширхэг 6□ 4 4+4+4+4+4=20 5 ширхэг 5□ 4 4+4+4+4+4+4+4=28 7 ширхэг 7□ 4 4+4+4+4=16 4 ширхэг 4□ 4 25. сурах бичгээс 2 бодлого ажиллуулна	Хугацаа хүрэлцээтэй бол сурах бичгээс дасгал ажиллах
Дүгнэлт 3 мин	-Ойлгосноо дүгнэж санаа бодлоо солилцоно.	26. Үржүүлэх үйлдлийн талаар хүүхдүүдийн санааг сонсож ярилцах боломж олгоно	самбарт буусан зүйлийг нэгтгэх

-Зөв хариулж буй эсэхдээ өөрийгөө болон бусдыгаа үнэлнэ.
Гэрийн даалгавар: сурах бичгийн дасгал № тэмдэглэж авах

Аман үнэлгээг хичээлийн алхам бүрт ашиглана.
Хүүхэд бие биенээ болон багаа үнэлнэ.
Сурагчдаа бие дааж ажиллаж байгаа үед нь ажиглана
Гэрийн даалгавар: гэр бүлийн гишүүдийн тоогоор бэлэг захиалж нэмэх ба үржих үйлдлээр тооцоолон гаргах
Дэвтэрт бичигдсэн байгаа доорх үйлдлийг үржүүлэх үйлдлээр бичүүлэх
 $7+7=$ $3+3+3+3=$ $4+6+2=$
 $10+10+10+10+10=$



Ойлгоогүй зүйл юу байгааг асууж ярилцах

Самбар төлөвлөлт

ЗЭРИН ҮНЭЛЭГ

САР ОДОР. ГАРВАНГ

ТОДОРХОЙЛОЛТ

ӨМНӨХ мэдлэг (эхлэл)	ШИНЭ мэдлэг БҮТЭЭХ (өрнөл)	Төгсгөл хэсэг.
$7+7=$ $3+3+3+3=$ $4+6+2=$ $10+10+10+10=$ * нэмэгдэхүүн + нэмэгдэхүүн = нэмэгдэх Үржүүлэх үржүүлэх	 ҮРЖИГДЭХҮҮН ҮРЖИГДЭХҮҮН = ҮРЖВЭР ҮРЖИХ ҮЙЛДЭЛЭН ТЭМДЭГ: * x	$6 \times 2 = 12$ $7 \times 2 = 14$ $4 \times 2 = 8$ $5 \times 2 = 10$ 

САР ОДОР.

④ СЭДЭВ. ЖИМСНИЙ тоог олцгооё.

⑨ $3 \times 7 = 21$
 $4 \times 2 = 8$
 $2 \times 10 = 20$

⑩ ИЖИЛ нэмэгдэхүүнүүдийн нийлбэрийг олох үйлдлийг үржүүлэх үйлдэл гэнэ.

⑪ ААЛГАВАР.

⑫ АЛИМ.

⑬ ХАН БОРТО ЦОЙ

⑭ ЖУРХ

⑮ $2+2+2+2=8$ $4 \times 2 = 8$

⑯ $2+2+2+2+2=10$ $5 \times 2 = 10$

⑰ $2+2+2+2+2+2=12$ $6 \times 2 = 12$

⑱ $2+2+2+2+2+2+2=14$ $7 \times 2 = 14$

Мэдлэг эзэмшилтийн судалгаа

I. I нэмэгдэхүүн 5, II нэмэгдэхүүн 26 бол нийлбэрийг ол.

II. $16 + \square = 18$.

Ямар гишүүнийг олсон бэ?

III. Нэмэх үйлдлийн гишүүдийн нэр аль нь вэ? Дугаарыг дугуйл.

A. хасагдагч, нийлбэр.

B. нэмэгдэхүүн, ялгавар.

B. нэмэгдэхүүн, нийлбэр.

IV. 6 чихрийг ижил тоотойгоор хэдэн янзаар багцалж, нэмж болох вэ? Бишиж үзүүлээрэй!

Мэдлэг эзэмшилтийн судалгаа

I. Шалгуур үзүүлэлт

1. Нэмэх үйлдлийн утга олох ч
2. Нэмэх үйлдлийн гишүүдийг ялгах, нэрлэх
3. Ажиглан дүгнэлт хийх
4. Нэмэх үйлдлээс нэмэгдэхүүнийг тогтоох
5. Математик хэллэг ашиглах
6. Нийлбэрийг ижил нэмэгдэхүүнүүдээр задлах

Жишээ дээдэлгээр

1. $26 + 15 =$

$42 + 18 =$

$18 + 11 =$

2. $\square + 33 = 65$

$19 + \square = 34$

I нэмэгдэхүүн 21 II нэмэгдэхүүн 16 бол нийлбэрийг олгоорой

3. $3 + 3 + 2 \neq 3 =$

$3 + 3 + 3 =$

$4 + 4 =$

$5 + 2 + 6 + 4 =$

4. $4 + 4 + 3 + 4 + 3 = (4 + 4 + 4) + (3 + 3) \neq$
бол

$2 + 5 + 5 + 2 + 5 = ?$

5. I нэмэгдэхүүн 5 ба II, III нэмэгдэхүүн мөн төчөөн бол нийлбэр нь хэд вэ? (Эцсийн үр дүнг бодож олжгооё!)

6. 12-ыг ижил нэмэгдэхүүнүүдээр (нийлбэрт) хэдэн янзаар задлаж болох вэ?

